



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/БНБ

Булган сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Монгол даатгал"ХХК-ийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг даргад холбогдох "Булган аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын гаргасан шийдвэрийг илт хууль бус болохыг тогтоож, төрийн үйлчилгээний цахим бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгах тухай" захиргааны хэрэгт хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүрэн төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Сүрэнхорын Амарыг томилсугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, үр дүнг мэдээлэхийг итгэмжлэгдсэн төлөөлөгч (С.Амар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

